



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагуудыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг "Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр"-т тусган батлуулж, хэрэгжүүлэхийг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/ -д тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080628

Эрүүл мэндийн сайдын 2017 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн
А/192 дугаар тушаалын хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагууд**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо	Шалгуур үзүүлэлтийг хангасан хувь
1.	Сөүл Сениорс Товер ХХК-ний "Улаанбаатар Сонгдо" эмнэлэг	43/2017	1 жил	2017-01-14	2018-01-14	93,0
2.	Интернэйшнл Медикал Сентр ХХК-ний "Интермед" эмнэлэг	44/2017	1 жил	2017-04-21	2018-04-21	97,6
3.	"Медика Монголиа" ХХК-ний эмнэлэг	45/2017	4 жил	2017-03-13	2021-03-13	93,9
4.	Баянгол дүүргийн "Мөнх-Үжин" өрхийн эрүүл мэндийн төв	46/2017	3 жил	2017-03-23	2020-03-23	90,5
5.	Хотонтрейд ХХК-ний "Энхжил эмнэлэг	47/2017	3 жил	2017-01-30	2020-01-30	90,1
6.	Элэг ХХК-ний "Элэг" эмнэлэг	48/2017	3 жил	2017-01-31	2020-01-31	90,9
7.	Нонаба ХХК-ний "Мөнхийн- Үйлс-2" эмнэлэг	49/2017	2 жил	2017-04-25	2019-04-25	88,8
8.	Шар бар ХХК-ний "Их зайсан" эмнэлэг	50/2017	1 жил	2017-05-13	2018-05-13	90,0
9.	"Энх Саран" ХХК-ний сувиллын газар	51/2017	4 жил	2016-12-31	2020-12-31	93,0
10.	"Амарсанаа гүнж" ХХК-ний сувиллын газар	52/2017	2 жил	2017-04-25	2019-04-25	88,1